



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2025



Улаанбаатар хот
2026 он



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2025 ОН

Улаанбаатар хот
2026 он

ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН:

Б.Баянжаргал

Холбоо, төрийн бус байгууллага, сууц өмчлөгчдийн
холбооны салбар хариуцсан мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.Чинжаргал

Хэлтсийн дарга

Б.Шинэцэцэг

Ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын Тамгын газрын байр
112, 114 тоот
Утас: 11-301637, 70122688
Цахим хаяг: bayangol@nso.mn
Цахим хуудас: <http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.ТЕХНИКИЙНХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст	8
ХҮСНЭГТ 2.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, дүүргээр, жил бүрийн эцэст	9
ХҮСНЭГТ 3.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, амины автомашин, үндсэн төрлөөр, нийслэлд эзлэх хувь, жил бүрийн эцсийн байдлаар.....	10
ХҮСНЭГТ 4.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, аж ахуй нэгж, байгууллагын автомашин, өмчлөлийн хэлбэрээр, жил бүрийн эцэст.....	11
ХҮСНЭГТ 5.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, хөдөлгүүрийн шатахууны төрлөөр, үндсэн төрлөөр, 2025 оны жилийн эцэст	12
ХҮСНЭГТ 6.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, хөдөлгүүрийн багтаамжаар, жил бүрийн эцэст	12
ХҮСНЭГТ 7.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, ашиглалтын хугацаагаар, жил бүрийн эцсийн байдлаар.....	13

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, улс, нийслэлд эзлэх хувиар, жил бүрийн эцэст	8
ЗУРАГ 2.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст	9
ЗУРАГ 3.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, аж ахуйн нэгж байгууллага, амины автомашин, үндсэн төрлөөр, 2025 оны жилийн эцсийн байдлаар.....	10
ЗУРАГ 4.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, амины автомашин, үндсэн төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар.....	11
ЗУРАГ 5.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, аж ахуйн нэгж байгууллагын автомашин, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст	11
ЗУРАГ 6.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, хөдөлгүүрийн багтаамжаар, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцсийн байдлаар.....	12
ЗУРАГ 7.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, үндсэн төрлөөр, хөдөлгүүрийн багтаамжаар, 2025 оны жилийн эцсийн байдлаар	13
ЗУРАГ 8.ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, ашиглалтын хугацаагаар, 2025 оны жилийн эцсийн байдлаар	14



ТЭЭВЭР

Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буурсан байна.

Монгол Улсын анхны автомашин Богд Хааны шилэн Форд 1912 онд замын хөдөлгөөнд оролцож байсан тэр үеэс өнөөг хүртэл 112 жилийг ардаа үджээ. Баянгол дүүрэгт 2025 оны байдлаар техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо 86745 болж, өмнөх оноос 6186 (6.7%) буурсан үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгээр 72551 суудлын, 12079 ачааны, 1293 автобус, 822 тусгай зориулалтын автомашин хамрагдаж өмнөх оноос суудлын автомашин 5360 (6.9%), ачааны автомашин 123 (8.7%), автобус 123 (8.7%) буурсан үзүүлэлттэй. Харин тусгай зориулалтын автомашин 12 (1.5%) буурсан байна.

ХҮСНЭГТ 1.

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст


Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	<u>2025</u> 2024
	тоо					хувь
Нийт дүн	77 701	78 540	83 154	92 931	86 745	-6.7
Суудлын	64 386	65 639	68 690	77 911	72 551	-6.9
Ачааны	10 877	10 540	11 960	12 794	12 079	-5.6
Автобус	1 461	1 467	1 435	1 416	1 293	-8.7
Тусгай зориулалтын	977	894	1 069	810	822	1.5

*-Урьдчилсан гүйцэтгэл

2025 оны байдлаар Баянгол дүүргийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины 83.7 хувь нь суудлын, 13.9 хувь нь ачааны, 1.5 хувь нь автобус, 0.9 хувь нь тусгай зориулалтын автомашин тус тус эзлээд байна.

ЗУРАГ 1.

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, улс, нийслэлд эзлэх хувиар, жил бүрийн эцэст



2025 оны жилийн эцсийн байдлаар техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины Монгол улсын 9.4 хувь, Нийслэлийн 16.3 хувь нь Баянгол дүүрэгт хамрагдсан байна. Техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан автомашиныг нийслэлийн хэмжээнд эзлэх

хувиар сүүлийн 5 жилийн хугацаанд авч үзэхэд 2021 онд хамгийн өндөр үзүүлэлттэй 18.1 хувь байсан бол 2025 онд хамгийн бага 16.3 хувийн үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Баянгол дүүргийн хэмжээнд үзлэгт хамрагдах автомшины тоо буурсан байна.

ХҮСНЭГТ 2.

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, дүүргээр, жил бүрийн эцэст


Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь
Нийт дүн	428 182	435 725	473 673	561 713	532 539	-5.2
Баянзүрх	101 033	101 918	111 399	130 998	125 777	-4.0
Баянгол	77 701	78 540	83 154	92 931	86 745	-6.7
Багануур	5 436	6 146	6 170	6 408	5 464	-14.7
Багахангай	715	693	733	868	838	-3.5
Налайх	5 563	5 730	6 685	7 528	7 676	2.0
Сонгинохайрхан	74 144	76 219	84 850	109 264	97 351	-10.9
Сүхбаатар	59 804	62 015	64 666	76 563	70 020	-8.5
Чингэлтэй	46 771	45 159	49 428	56 495	43 137	-23.6
Хан-Уул	57 015	59 305	66 588	80 658	95 531	18.4
Нийслэлийн дүнд эзлэх %	18.1	18.0	17.6	16.5	16.3	-

Улаанбаатар хотод нийтдээ 532539 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсны 125777 (23.6%) нь Баянзүрх, 97351 (18.3%) нь Сонгинохайрхан, 86745 (16.3%) нь

Баянгол, 70020 (13.2%) нь Сүхбаатар, 95531 (17.9%) нь Хан-Уул, 43137 (8.1%) нь Чингэлтэй, 13978 (2.6%) нь Багануур, Багахангай, Налайх дүүргүүд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2.


ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст



Нийт техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоог автомашины төрлөөр нь өмнөх онтой харьцуулахад суудлын автомашин, ачааны автомашин өсөж, тусгай зориулалтын автомашин, автобус буурсан төлөв ажиглагдаж байна. Үүнээс тусгай зориулалтын суудлын автомашин хамгийн

өсөлттэй буюу 1.5 хувиар өссөн бол автобус 8.7 хувиар буюу хамгийн бага бууралт үзүүлсэн байна. Нийт техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины 33.9 (36.4%) мянга нь аж ахуй нэгж байгууллагын автомашин, 59.1 (63.6%) мянга нь иргэд хувь хүмүүсийн амины автомашин тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3. ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, аж ахуй нэгж байгууллага амины автомашин, үндсэн төрлөөр, 2025 оны жилийн эцэст



Амины автомашин: Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр бүх төрлийн тээврийн хэрэгслийн ихэнх нь хувийн өмч болж, авто тээврийн үйлчилгээ бараг бүхэлдээ хувийн хэвшилд очсон байна. Дүүргийн хэмжээнд хувь

хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй нийт амины автомашины тоо 53390 хүрч, өмнөх оноос 5684 (9.6%) мянгаар буурсан байна. Дүүргийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины 61.8 хувийг амины автомашин эзэлж байна.


ХҮСНЭГТ 3. ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, амины автомашин, үндсэн төрлөөр, нийслэлд эзлэх хувь, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь
Нийт дүн	49 400	49 889	51 811	59 074	53 390	-9.6
Суудлын	43 039	43 834	45 628	52 118	47 294	-9.3
Ачааны	5 490	5 182	5 270	6 048	5 204	-14.0
Автобус	498	526	528	628	580	-7.6
Тусгай зориулалтын	373	347	385	280	312	11.4
Нийслэлд эзлэх хувь	16.9	16.9	16.5	16.0	15.6	-

2025 оны байдлаар Баянгол дүүргийн техникийн үзлэгт 53390 амины автомашинаас хамрагдсанаас 47294 (88.6%) нь суудлын, 5204 (9.7%) нь ачааны, 580 (1.1%) нь автобус, 312 (0.6%) нь тусгай зориулалтын автомашин тус тус эзлээд байна. 2025 онд техникийн хяналтын

үзлэгт хамрагдсан иргэд хувь хүмүүсийн амины автомашины тоо хэмжээ хамгийн өндөр буюу 53390 байгаа бөгөөд нийслэлийн хэмжээнд 15.6 хувийг эзэлж байна. Харин 2025 онд хамгийн их дүнтэй буюу 59074 автомашин хамрагдсан нь нийслэлийн дүнд 16.0 хувийг эзэлж байсан байна.

ЗУРАГ 4.

ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, амины автомашин, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст


Нийт техникийн үзлэгт хамрагдсан амины автомашины тоог өмнөх онтой харьцуулахад тусгай зориулалтын автомашины тоо өсөж суудлын автомашин, ачааны автомашин, автобусны тоо буурсан байна. Ачааны автомашины тоо хамгийн өндөр буюу 14.0 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 4.


ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, аж ахуй нэгж байгууллагын автомашин, өмчлөлийн хэлбэрээр, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь
Нийт дүн	28 301	28 651	31 343	33 857	32 964	-2.6
Төрийн болон орон нутгийн өмчийн	575	622	648	796	582	-26.9
Дипломат, олон улсын байгууллагын	7	13	9	12	12	-
Санхүүгийн байгууллагын	-	9 717	20 409	22 963	23 408	1.9
Хувийн хэвшлийн	27 719	18 299	10 277	10 086	8 962	-11.1
Нийслэлд эзлэх хувь	6.6	6.6	6.6	6.0	6.2	-

Дүүргийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт аж ахуйн нэгж, байгууллагын автомашины тоо 32964 болж, өмнөх оноос 893 (2.6%) автомашинаар буурсан байна. 2025 онд техникийн хяналтын үзлэгт орсон аж ахуйн нэгж, байгууллагын автомашины 1.8 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.04 хувийг

дипломат болон олон улсын байгууллагын, 71.0 хувийг санхүүгийн байгууллагын, 27.2 хувийг хувийн хэвшлийн байгууллага тус тус эзэлж байна. Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс аж ахуй нэгжийн автомашин нийслэлийн хэмжээнд 6.0-6.6 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 5.

ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, аж ахуй нэгж байгууллагын автомашин, үндсэн төрлөөр, жил бүрийн эцэст


Дүүргийн хэмжээнд авто замын хөдөлгөөнд идэвхтэй оролцож буй техникийн хяналтын үзлэгт хамрагдсан 32964 аж ахуйн нэгж байгууллагын автомашины 24949 (75.7%) суудлын автомашин, 6818 (20.7%) нь ачааны, 696 (2.1%) нь автобус, 501 (1.5%) нь тусгай зориулалтын автомашин байна.

ХҮСНЭГТ 5.

ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, хөдөлгүүрийн шатахууны төрлөөр, үндсэн төрлөөр, 2025 оны жилийн эцэст

Үзүүлэлт	Бүгд	Үүнээс: автомашины үндсэн төрлөөр			
		суудлын	ачааны	автобус	Тусгай зориулалтын
	тоо				
Нийт дүн	86745	72 551	12 079	1 293	822
Бензин	23 198	21 232	1 550	372	44
Дизель	14 127	1 989	10 478	884	776
Хосолсон	48 511	48 489	19	1	2
Цахилгаан	125	110	14	1	-
Газ	784	731	18	35	-

Суудлын автомашины 66.8 хувь нь хосолсон, ачааны автомашины 86.7 хувь, автобусны 68.4 хувь, тусгай зориулалттай автомашины 94.4 хувь нь тус бүр дизель хөдөлгүүртэй байна.

ХҮСНЭГТ 6.


ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, хөдөлгүүрийн багтаамжаар, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь
Нийт дүн	77 701	78 540	83 154	92 931	86 631	-6.8
1500 см ³ хүртэл	24 184	21 761	20 064	19 129	15 085	-21.1
1501-2500 см ³	32 491	35 129	39 073	47 734	46 396	-2.8
2501-3500 см ³	9 846	10 582	11 400	13 406	12 779	-4.7
3501-4500 см ³	3 151	3 078	3 386	3 622	3 434	-5.2
4501 см ³ -ээс дээш	8 029	7 990	9 231	9 040	8 937	-1.1

2025 онд Баянгол дүүргийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан 86631 автомашиныг хөдөлгүүрийн багтаамжаар авч үзэхэд хамгийн өндөр 53.6 хувийг 1501-2500 см³ хөдөлгүүрийн багтаамжтай автомашин эзэлж байна.

ЗУРАГ 6.


ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, хөдөлгүүрийн багтаамжаар, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцэст



Нийт техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашиныг хөдөлгүүрийн багтаамжаар нь ангилж үзэхэд 53.6 хувийг 1501-2500 см³, 17.4 хувийг 1500 см³ хүртэл, 14.8 хувийг 2501-3500 см³, 10.3 хувийг 4501 см³-ээс дээш багтаамжтай, 4.0 хувийг 3501-4500 см³ хүртэл багтаамжтай автомашин тус тус эзэлж байна. Өмнөх оноос 1500 см³ хүртэл багтаамжтай автомашин 4044 (21.1%), 1501-2500 см³ багтаамжтай 1338 (2.8%), 2501-3500 см³ багтаамжтай 627 (4.7%), 3501-4500 см³ багтаамжтай 188 (5.2%), 4501 см³-ээс дээш багтаамжтай 103 (1.1%) автомашинаар тус тус буурсан байна.

ЗУРАГ 7.

ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, үндсэн төрлөөр, хөдөлгүүрийн багтаамжаар, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцэст



Автомашинны үндсэн төрөл тус бүрд хөдөлгүүрийн багтаамжаар ангилж үзэхэд суудлын автомашинны 58.6 хувь нь 1501-2500 см³ хөдөлгүүрийн багтаамжтай байгаа бол ачааны автомашинны 51.2 хувь нь 4501 см³-ээс

дээш, автобусны 30.6 хувь нь 2501-3500 см³, Тусгай зориулалтын автомашинны 73.8 хувь нь 4501 см³-ээс дээш хөдөлгүүрийн багтаамжтай байна.


ХҮСНЭГТ 7.

ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО, ашиглалтын хугацаагаар, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь
Нийт дүн	77 701	78 540	83 154	92 931	86 745	-6.7
0-3 жил	1 110	1 757	2 430	2 456	2 835	15.4
4-9 жил	11 017	9 347	8 826	10 377	10 334	-0.4
10-аас дээш жил	65 574	67 436	71 898	80 098	73 576	-8.1
дүнд эзлэх хувиар						нэгж хувиар
0-3 жил	1.4	2.2	2.9	2.6	3.3	0.7
4-9 жил	14.2	11.9	10.6	11.2	11.9	0.7
10-аас дээш жил	84.4	85.9	86.5	86.2	84.8	-1.4

Баянгол дүүрэгт 2025 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашиныг ашиглалтын (насжилт) хугацаагаар нь ангилж үзэхэд 0-3 жил ашиглагдаж буй 2835 (3.3%) мянга, 4-9 жил ашиглагдаж буй 10334 (11.9%) мянга, 10 ба түүнээс дээш жил ашиглагдаж буй 73576 (84.8%) мянган тээврийн хэрэгсэл байна.

Нийт техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийг өмнөх онтой харьцуулахад 0-3 жил ашигласан автомашин хамгийн өндөр буюу 379 (15.4%) тээврийн хэрэгслээр өссөн бол, 10-с дээш жил ашигласан автомашин хамгийн бага буюу 6522 (8.1%) тээврийн хэрэгслээр буурсан байна.



Хяналтын үзлэгт хамрагдсан автомашины үндсэн төрлүүдийг ашиглалтын хугацаагаар нь ангилж үзэхэд суудлын автомашины 85.3 хувь, ачааны автомашины 12.4 хувь, автобусны 1.5 хувь, тусгай зориулалттай автомашины 0.9 хувь нь тус бүр 10-аас дээш жил ашиглан автомашинууд байна.

Ойлголт, тодорхойлолт:

Ачаа эргэлт: Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт: Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Шилжүүлсэн тонн километр: Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрд харилцан адилгүй тооцогддог.

Тээврийн орлого: Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.

Эх үүсвэр:


ҮСХ, Зам тээврийн яам,
Иргэний нисэхийн ерөнхий газар,
Төмөр замын газар,
НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

ҮСХ, "Тээврийн статистикийн аргачлал" 2008 он



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn
www.ubstat.mn



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



Баянгол дүүргийн
Статистикийн хэлтэс



[www.twitter.com/
statistic_mn](https://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



Download on the
App Store

 **Google play**



Утсаар:



11-301637
70122688
70122668

